

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал түүний ажлын хэсэг:

Дорноговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 10 дугаар хуралдаан

Дорноговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 10 дугаар хуралдаан 2019 оны 04-р сарын 08-ны өдөр 93.54% хувийн ирцтэйгээр аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд хуралдаан боллоо. Тус хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд:

1. Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай
2. Газрыг тусгай хамгаалалтад авах тухай
3. Журам батлах тухай (*Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэ төлбөргүй, оюутан, сурагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах журам*)
4. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэ тогтоох тухай
5. Мод тарих тухай иргэд, байгууллагуудад уриалга гаргах тухай
6. Зарим тогтоолыг хүчингүй болгох тухай
7. Камержуулах аян зарлах тухай /тогтоол, зөвлөмж/
8. Шашны байгууллагуудад зөвшөөрөл олгох тухай
9. Бусад асуудал

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 10 дугаар хуралдааны үеэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчид айл өрх, иргэн, байгууллага бүр мод тарьцгаая нэртэй уриалга гаргалаа.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Дорноговь аймгийн харьяат иргэд, албан тушаалтны төлөөллийг БНХАУ-ын Эрээн хотод 2019 оны 04 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд мод тарих, арчлах, ургуулах тухай сургалтад хамруулж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /ГХУСАЗСЗ/, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл, урлагийн газар хамтран “Өсвөрийн сэргийлэгч-2019” тэмцээнийг 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Хүүхдийн ордонд зохион байгууллаа.

Тус тэмцээний зорилго нь Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүлгэмүүд харилцан туршлага судлах, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сургуулийн болон гэр бүлийн орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн юм. Тус тэмцээнийг нээлтийн үйл ажиллагааг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хонгорзул нар тус тус оролцсон юм.

Тэмцээнд Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 5 дугаар сургуулиуд, Зүүнбаян багийн 4 дүгээр сургууль, Замын-Үүд сумын нийт сургуулиас бүрдсэн “Өсвөрийн сэргийлэгч”-ийн нийт 6 бүлэг тус бүр нийгмийн ажилтан болон хариуцсан багшийн хамт оролцож байгаа бөгөөд тэмцээнд шалгаран тэргүүн байр эзэлсэн баг хамт олныг дараагийн шатны тэмцээнд оролцуулах юм.

“Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн ажилд арга туршлага болохуйц хэрэгжүүлэх боломжтой шинэлэг санааг хэрхэн тусгасан, үр дүнгийн байдлыг гол шалгуур үзүүлэлт

болгон харгалзан дүгнэж шалгарсан багуудыг аймгийн ГХУСАЗСЗ-өөс дараах байдлуудаар урамшууллаа. Үүнд:

- Нэгдүгээр байр- Өргөмжлөл, медаль, 500000 төгрөг

-Хоёрдугаар байр- Өргөмжлөл, медаль, 300000 төгрөг

- Гуравдугаар байр- Өргөмжлөл, медаль, 200000 төгрөгөөр, мөн бүлгэмийг амжилттай бэлтгэж оролцуулсан 1 нийгмийн ажилтан, хариуцсан багш тус бүрийг өргөмжлөл, 50000 төгрөгөөр шагнаж урамшуулаа.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дорноговь аймгийн ЗДТГ, Монголын шатрын холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Биеийн тамир спортын газраас Говийн бүсийн аймгуудын өсвөрийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд аймгийн “Соёмбо” цогцолборын “Хүндэтгэлийн өргөөн”-нд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга бөгөөд Монголын шатрын холбооны Дорноговь аймаг дахь зөвлөлийн Тэргүүн С.Түмэнбаяр, аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, ОУ-ын шатрын холбооны мастер Ж. Лхагваа, Монголын шатрын холбооны Дорноговь аймаг дахь зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ү.Бадамдорж, аймгийн Биеийн тамир спортын газрын дарга Г.Батлхам нар тус тус оролцож нийт баг, тамирчдад амжилт хүсэн ерөөлөө. Энэхүү тэмцээний онцлог нь Монгол Улсын аварга шатарчин шалгаруулах тэмцээнд нийтдээ хамгийн олон удаа буюу 24 удаа шалгаран оролцож 315 өрөг тоглосны 159 өрөгт хожиж байсан түүхтэй Монголын шатрын нэрт зүтгэлтэн, Монгол Улсын 6 удаагийн аварга, ОУ-ын шатрын холбооны мастер Жамбалдоогийн Лхагваагийн нэрэмжит болж байгаагаараа онцлог байлаа.

Ж.Лхагваагийн нэрэмжит энэхүү тэмцээнийг анх 2017 онд Дундговь аймагт зохион байгуулагдсанаас хойш ийнхүү 3 дахь удаагийн тэмцээнийг манай аймаг зохион байгуулж байна.

Жилээс жилд өргөжин тэлж байгаа Жамбалдоогийн Лхагваагийн нэрэмжит Говийн бүсийн өсвөрийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд оролцохоор Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын нийт 180 гаруй тамирчид оюун ухаан, авхаалж самбаагаа өрсөлдүүлсэн юм. Энэхүү тэмцээний нээлтийн үеэр аймгийн ИТХ-ын даргын Хүндэт өргөмжлөлөөр ОУ-ын шатрын холбооны мастер Ж.Лхагвааг, аймгийн ИТХ-ын даргын өргөмжлөлөөр Г.Мөнхсүх, Э.Зол-Учирал нарыг тус тус шагнаж урамшууллаа. . Багийн нийлбэр дүнгээр 1-р байранд Дорноговь аймаг, 2-р байранд Өмнөговь аймаг, 3-р байранд Говьсүмбэр аймаг тус тус эзлэлээ.

Сайншанд сумын бүх багуудад Иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулагдлаа. Тус хуралд Дорноговь аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Дорноговь аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Сайншанд сумын ИТХ-ын төлөөлөгчид холбогдох багийн Засаг дарга нар, Сайншанд сумын ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын тасгийн дарга Л.Олзбаяр тус тус оролцож нийт иргэдэд мэдээлэл хийж, иргэдэд тулгамдаж буй асуудлуудад газар дээр нь хариулт өгч мөн зарим асуудлуудыг дээд шатны байгууллагуудад уламжлан өгч ажиллахаар болсон юм. Мөн тус хурлаар Сайншанд суманд Орон нутгийн хөгжлийн сангаас 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар иргэдээс санал авч эрэмбэлэн тогтоол гаргалаа, Сайншанд сумын 4-р багийн хил зааг тодорхойлох санал дүгнэлтийг

хэлэлцүүлж иргэдээс санал авч, Сайншанд сумын 4-р багийн хил зааг тогтоох тухай дэмжсэн тогтоолыг тус тус гаргасан юм.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ээлжит 5 дугаар хуралдаан

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит 5 дугаар хуралдаан болж байна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлууд:

1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайд санал өгөх тухай
 2. “Чандмань-Илч” орон нутгийн өмчит ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
 3. Монгол Улсын Төрийн дээд шагналд уламжлах тухай
 4. Бусад асуудал
- Хөрөнгө зарцуулах тухай /Цэцэрлэгт хүрээлэнд мод тарихтай холбогдуулан/

Аймгийн ИТХ-ын даргын өргөмжлөл

04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Аймгийн ИТХ-ын даргын” Хүндэт өргөмжлөл”-өөр нийт 1 иргэн, “Өргөмжлөл”-өөр нийт 7 иргэн шагнагдаад байна.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж

04 дүгээр сард нийт аймгийн ИТХ-ын даргын 8 захирамж гарсанаас ангилахад Шагнах тухай-2, Дэмжлэг үзүүлэх-5, мөнгөн тусламж-1 тус тус болно.

Аймгийн ИТХ-ын ажлын албанд ирүүлсэн албан бичиг, өргөдлийн тухайд:

Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 41 албан бичиг ирж, ажлын албанаас нийт 42 албан бичиг гадагшаа байгууллагуудруу явсан болно. Иргэдээс аймгийн ИТХ-д нийт 3 өргөдөл ирүүлснээс хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажилласан болно.

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газар

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс: Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийн хүрээнд ажлаас үндэслэлгүй халагдсан албан хаагчдын мэдээлэл, түр орлон гүйцэтгэгч нарын судалгаа, төрийн албан хаагчдын зэрэг дэвийн материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн захиргааны албан хаагчдын бүртгэл, судалгаа авч сум, агентлагаар нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан 14 сум, 10 агентлагийн албан тушаалын тодорхойлолтыг хянуулж зөвшөөрөл авахаар төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын анкетийг шинэчилж хувийн хэргийн баяжилтийг хийсэн.

Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад шинэ мэдээ, мэдээлэл хүргэх зорилготой “Иргэн төвтэй

төрийн үйлчилгээ-2019” Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн, сургалт 04 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд аймгийн “Саран хөхөө” театрт зохион байгуулагдаж байна. Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчид энэхүү зөвлөгөөн, сургалтад хамрагдлаа.

Тус зөвлөгөөнөөр төрийн албан хаагчдад “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хийгдэх ажлын мэдээлэл, танилцуулга өгөх, Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлт, холбогдох дүрэм журмыг сурталчлах, байгууллагын стратеги төлөвлөгөө, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зам, архив, албан хэрэг хөтлөлтийн салбарт анхаарах асуудлууд зэрэг олон тусгай хөтөлбөрүүдийг багтаасан арга хэмжээ зохион байгуулагдсан юм.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр 18 багийн Засаг дарга нарыг бусад сумдын багуудад ажлын 14 хоногийн хугацаатай сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж иргэдээс 30 өргөдөл, гомдол ирүүлснээс 23 өргөдлийг нь хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд хугацаа болоогүй судлагдах шатандаа 7 өргөдөл байна.

-Аймгийн Засаг дарга 4-р сард нийт 12 иргэнийг өөрийн биеэр хүлээн авч, уулзан санал хүсэлтийг шийдвэрлэн ажилласан.

-Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар ирүүлсэн 53 иргэний материалыг хүлээн авч хянан үзээд 47 иргэний материалыг холбогдох дээд байгууллагын саналыг авч аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

-Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах тухай нийт 56 материал хүлээн авч хянан үзээд аймгийн Засаг даргын Жуух бичгээр 5, өргөмжлөлөөр 19 хүнийг шагнаж урамшуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сум, БНХАУ-ны ӨМӨЗО-ны Бугат хотын Дархан Муу Мянган Холбоот Хошуу хоорондын хамтын ажиллагааны хүрээнд сумын ЗДТГ-ын 10 албан хаагч 2019 оны 04 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд Дархан Муу Мянган Холбоот Хошуунд эдийн засаг, худалдааг хамтран хөгжүүлэх болон соёл, спорт, урлаг, эрүүл мэнд, боловсрол, боловсон хүчин зэрэг салбаруудад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд санал солилцох, төрийн албаны үйл ажиллагаа, хот тохижилтын үйл ажиллганы арга туршлагаас судлах, хот төлөвлөлт, бүтээн байгуулалттай танилцах зорилгоор туршлага судлаад ирсэн.

Туршлага судлахаар явсан албан тушаалтнууд:

№	Овог, нэр	Албан тушаал
1	Сайнхүүгийн Одбаяр	Сайншанд сумын Засаг дарга
2	Батдорж Жаргалсайхан	“Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын дарга
3	Довчингийн Мөнхбаяр	Сайншанд сумын I багийн дарга
4	Тэрбишийн Гантулга	Сайншанд сумын II багийн Засаг дарга
5	Цэвэгбаатарын Анхзул	Сайншанд сумын IV багийн Засаг дарга
6	Цэрэнпунцагийн Ганзориг	Сайншанд сумын V багийн Засаг дарга
7	Энэбишийн Уранчимэг	Сайншанд сумын VI багийн Засаг дарга

8	Төмөр-Очирын Алтанболд	Сайншанд сумын VII багийн Засаг дарга
9	Цоодолын Энхжин	Хэвлэл мэдээлэл, мэдээллийн харилцаа хариуцсан мэргэжилтэн
10	Батболдын Болдсайхан	Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Туршлага судалсан байгууллагууд:

- Дархан Муу Мянган Холбоот Хошууны Ардын Засгийн Ордон
- Хошууны Соёл мэдээллийн төв
- Улсын цэцэрлэг
- Улсын сургууль
- Хот тохижилтын байгууллага

Айлчлалын хүрээнд дэвшүүлэн хэлэлцсэн санал:

- Хөрөнгө оруулалтын чиглэлээр:
 - o II сургуулийн хөл бөмбөгийн талбай
 - o Хаврын мод тариалалтанд 35000 мод нийлүүлэх

Аймгийн Засаг дарга, түүний ажлын хэсэг айлчлал хийх үедээ харилцан тохирсон дээрх 2 ажилд хамтран ажиллахаа мэдэгдэж, хугацаа болон зохион байгуулалтын ажлыг эрчимжүүлэн ажиллахаар болсон:

- Төрийн албан хаагчдыг солилцох, туршлага судлах
 - o Багш солилцох
 - o Уламжлалт анагаах ухаан, өрхийн эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг туршлага судлуулах
 - o Соёл урлаг (Уран бүтээлчдийг солилцох, туршлага судлуулах)
 - o Хот тохижилтын чиглэлээр туршлага солилцох

Дээрх асуудлуудаар санал дэвшүүлсэн бөгөөд хамтран ажиллах гэрээний дагуу хүлээн авагч талаас судалж үзэн хариу мэдэгдэхээр болсон.

2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулсан Хятад, Монгол, Оросын “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын нэгдсэн холбооны 2019 оны ажлын хурал буюу 3 орны таван нутгийн нэгдсэн уулзалтад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн Х.Отгонжаргал, БОАЖГ-ын дарга Д.Сүрэн нар оролцоод ирлээ.

Тус уулзалтад БНХАУ-ын 25 гишүүн, ОХУ-ын 5 гишүүн, Монгол улсын 8 төлөөлөгч оролцож өнгөрсөн 3 жилийн ажлаа дүгнэж, цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөсөн. Үүнд:

Цайны замыг дэлхийн соёлын өвд бүртгүүлэх, олон талт арга хэмжээг хамтран зохион байгуулах

- Цайны замын дагуу орших сумдад соёлын биет болон биет бус өвийн эвент арга хэмжээний нэр, төрлийг нэмэгдүүлж, хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Цайны замын бүс нутгийн аялал жуулчлалыг сурталчлах зорилгоор Герман, Англи, УБ зэрэг газруудад зохион байгуулагдах аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт арга хэмжээнд оролцох
- Цайны замын бүс нутгийн сонгодог бүтээлүүдийг шалгаруулж, аялал жуулчлалыг нөөц баялаг болгон ашиглах, соёлын өвөөр дамжуулан сурталчлах
- Цайны зам аялал жуулчлалын холбооны гишүүдийг нэмэгдүүлэх
- Цайны замын гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах

Уулзалтаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны соёл, аялал жуулчлалын тэнхим, яамны гадаад солилцооны газар, Фү Жянь муж, Жян ши муж, Ху нань муж, Ху бэй муж, Шань ши муж, Хуан Шань хотын соёл, аялал жуулчлалын тэнхим, Буриад, Эрхүү, Красноярсийн аялал жуулчлалын газар, Улаанбаатар хотын аялал жуулчлалын газар, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн БОАЖГ-ын дарга нар аялал жуулчлалын салбарт барьж байгаа бодлого хөтөлбөр, зохион байгуулсан ажлын талаар илтгэл тавьж, видео танилцуулгыг нийт оролцогчидод танилцуулсан.

2019 онд зохион байгуулах томоохон арга хэмжээ:

1. “Цайны зам” аялал жуулчлалын холбоо, БНХАУ-ын Эрээн хот болон Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2015 оноос хойш зохион байгуулагдаж байгаа Талын салхи мото аялалын арга хэмжээ 06 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд болно. Энэ жилийн “Талын салхи” аялалд 100 гаруй оролцогчид оролцож манай аймагт байрлана. Тус аялалд оролцогчдийг байрлуулах буудал, хүлээн авахад хамтран ажиллах талаар санал хүсэлтээ албан бичгээр уламжлахаар шийдвэрлэсэн.

2. 06 сарын 26, 27-ны өдрүүдэд Цайны замын бүс нутгуудын удирдлагуудын уулзалт ӨМӨЗО зохион байгуулагдана.

3. Цайны замын бүс нутгийн хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг сурталчлах үзэсгэлэн 9 сард ӨМӨЗО-ны Улаанцавд зохион байгуулагдана.

4. Дэлхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн үзэсгэлэнг БНХАУ-д 11 сард тус тус зохион байгуулагдахаар Цайны зам олон улсын аялал жуулчлалын холбоо төлөвлөн бэлтгэл ажлаа хангаж байгаагаа мэдэгдсэн.

Дээрх уулзалтад оролцсноор БНХАУ, ОХУ болон бусад аймгийн аялал жуулчлалын талаар хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөр, хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх, 1 өдрийн, 3 өдрийн аялал жуулчлалыг дагаж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

талаар мэдээлэлтэй болж, цаашид аймгийн аялал жуулчлалыг мастер төлөвлөгөөнд тусгах ажлын чиг баримжааг олж авсан.

Нийгмийн бодлогын хэлтэс:

Нийгмийн даатгалын сангийн орлого зарлага

Нийгмийн даатгалын хэлтэс 2019 онд нийгмийн даатгалын санд 29949216,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 16578 иргэнд 41934483,0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгохоор ажиллаж байна.

Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

2019 оны 03 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын санд 6681002.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 8427421.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, сангийн орлого 126.14 хувийн биелэлттэй байна. Нийгмийн даатгалын сангаас 10163 иргэнд 10231782.7 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгож ажиллалаа.

Үүнийг сан тус бүрээр харуулбал:

Орлого /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	5430215.3	6361645.35	117.15
Тэтгэмжийн даатгалын сан	563483.6	721248.80	128.00
ҮОМШӨ-ний даатгалын сан	569876.9	1053274.40	184.82
Ажилгүйдлийн даатгалын сан	117426.7	291252.65	248.03
Дүн	6681002.50	8427421.20	126.14

Зардал /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
		Мөнгөн дүн	Хувь	Хүний тоо
Тэтгэврийн даатгалын сан	9112186.60	9050453.06	99.32	8313
Тэтгэмжийн даатгалын сан	712028.10	700189.20	98.34	1551
ҮОМШӨ-ний даатгалын сан	384530.30	222453.10	57.85	164
Ажилгүйдлийн даатгалын сан	254525.40	258687.40	101.64	135
Дүн	10463270.40	10231782.76	97.79	10163

1.1 Тэтгэврийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэвэрт нийт 8313 хүнд 9042620.2 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. Үүнд:

Мян.төг

Тэтгэврийн даатгалын сан	Тэтгэвэр авагчийн тоо	Олгосон тэтгэвэр
Өндөр насны тэтгэвэрт	6101	6725752.5
Тахир дутуугийн тэтгэвэрт	1270	1053547.7
Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	506	442457.7
Цэргийн тэтгэвэр	436	820862.3
Дүн	8313	9042620.20

1.2 Тэтгэмжийн даатгалын сангаас нийт 1551 даатгуулагчилд 699152.2 мянган төгрөгийн тэтгэмж олгосон.

Үүнд:		
ХЧТА-ний тэтгэмжинд	1181 хүнд	174654.9 мянган төгрөг
Жирэмсэн амаржсаны тэтгэмжинд	283 хүнд	437497.3 мянган төгрөг
Оршуулгын тэтгэмжинд	87 хүнд	87000.0 мянган төгрөг

1.3 ҮОМШӨ-ний даатгалын сангаас 164 даатгуудагчид 222453.23 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон. Үүнд:

Тахир дутуугийн тэтгэвэрт	121 хүнд	176217.8 мянган төгрөг
Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	29 хүнд	38026.7 мянган төгрөг
Тэтгэмж, төлбөр	12 хүнд	6875.03 мянган төгрөг
ҮОМШЭ-ийн сувиллын зардал	2 хүнд	1333.7 мянган төгрөг

1.4 Ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 135 даатгуулагчид 258687.4 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн авлага

Мянган төгрөг

Сангийн авлага	2018.12.31-ны байдлаар	2019.03.31-ний байдлаар
Нийт шимтгэлийн авлага	1515846,5	1651977,7
Төсөвт байгууллага	35086,9	252080,3
ААН байгууллага	1480759,6	1399897,5

Гурав. Өмнөх оны харьцуулалт

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 3 сард

Үзүүлэлт	2018.03	2019.03	2019 3 2018 3
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	6753,8	8427,3	124,8
Тэтгэврийн даатгалын сан	5097,4	6361,6	124,8
Тэтгэмжийн даатгалын сан	577,7	721,2	124,8
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0	0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	844,5	1053,3	124,7
Ажилгүйдлийн даатгалын сан	234,2	291,2	124,3
Нийгмийн даатгалын сангийн зарлага	9009,1	12085,6	134,1
Тэтгэврийн даатгалын сан	7749,2	9050,4	116,8
Тэтгэмжийн даатгалын сан	601,6	700,2	116,8
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0	0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	485	749,3	154,4
Ажилгүйдлийн даатгалын сан	172,9	258,7	149,6

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 3 сард

Үзүүлэлт	2018.03	2019.03	2019.03 2018.03
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	16288,0	16810,0	103,2
Албан журмаар даатгуулагчид	14068,0	14885,0	105,8
Аж ахуй нэгж, байгууллага	6890,0	7488,0	108,7
Төсөвт байгууллага	7178,0	7397,0	103,1
Сайн дураар даатгуулагчид	2220,0	1925,0	86,7
2. Тэтгэвэр авагчдын тоо	8016	8463	105,6
Өндөр насны тэтгэвэр	5745	6101	106,2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1188	1270	106,9
Тэжээгчээ алдсаны	519	506	97,5
Цэргийн тэтгэвэр	406	436	107,4
ҮОМШӨ*-ний	158	150	94,9

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН САРЫН МЭДЭЭ: 2019 04-р сар

- Ажилд зуучлагдсан иргэдийн тоо: 164
- Шинэ ажлын байрны тоо: 3
- Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо: 672
- Ажлын байрны захиалгын тоо: 143

1. ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

• Сайншанд сумаас зарласан “Багийн хөгжлийг дэмжих жил” –ийн хамтын ажлын хүрээнд 2019 оны 04 сарын 11,12-ны өдрүүдэд Засаг захиргааны анхан шатны нэгж болох багийн ажлын алба болон тухайн багийн иргэдэд хөдөлмөр эрхлэлт, Халамжийн үйлчилгээний чиглэлээрх хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах зорилгоор “Нэг зорилго-Нэг мэдээлэл” сэдэвт мэдээлэл зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Сайншанд сумын 1,2,3,4,6,7-р багийн хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан болон 117 иргэн хамрагдаж, ХХҮГ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хүнсний эрхийн бичиг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, хөдөлмөр эрхлэх боломжуудын талаар мэдээллийг өгч ярилцлага зохион байгууллаа.

- Сайншанд сумаас зарласан “Багийн хөгжлийг дэмжих жил” –ийн нээлтийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийн талаар үйлчилгээ үзүүллээ.

2. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын хүрээнд:

2. Сарын аяны нээлтийн талаар иргэд олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор салбар зөвлөлийн гишүүдийг " Дотно сэдэв " тв нэвтрүүлэгт бэлтгэсэн.

3. Нээлтийг 2019.04.04-нд " Эрүүл аюулгүй хөдөлмөрийн төлөө " уриан дор зохион байгуулж төрийн болон төрийн бус 18 байгууллага, Уул уурхайн 4 компани оролцож нийт 394 иргэн ирж сонирхлоо.

5. Сумдын салбар зөвлөлийн 120 гишүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулан Аймгийн салбар зөвлөлөөс цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ чиглэл өгч ажиллалаа.

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудын дунд “ Дэвжээ-2019 ”, “ Шилдэг илтгэл ” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар удирдамж боловсруулан аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлсэн.

7. ЕБСургуулийн сурагчдад ХАБЭА-н мэдлэг олгох зорилгоор Сайншанд сумын 3,5-р сургууль, МСҮТөвийн оюутан нийт 110 сурагчдад сургалт мэдээллийн ажлыг 2019.04.20-ны зохион байгууллаа.

8. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн тогооч, туслах тогооч нарт ХАБЭА-н талаар сургалт арга хэмжээг 2019.04.20-ны өдөр зохион байгууллаа.

10. Сумдын салбар зөвлөлийн дарга, Төрийн байгууллагуудын дарга, хүний нөөцийг чадавхижуулах сургалтыг 2019.04.19-ний зохион байгууллаа.

3. Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1. *Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:*

Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн төсөл хүлээн авах хугацаа 2019-04-12-оор дуусгавар болж нийт 18 /оёдол, газар тариалан, модон эдлэл, талх нарийн боов, гахай тахиа үржүүлэг, модон эдлэл, фото зураг, гар урлал, үсчин, хэрчсэн гурил гэх мэт/ төслийг хүлээн аваад байна.

Ахмадын зөвлөх үйлчилгээнд 3 байгууллага / Сайншанд сумын 13-р цэцэрлэг, Мишээлт мана, Агатова өрхийн эмнэлэг/ хүсэлт ирүүлсэн байна.

2. *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:*

Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдахаар 20 иргэн бүртгүүлсэн. Бүртгүүдсэн иргэдийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл гахай тахиа, оёдол, гутал засвар, газар тариалан, гар урлал, хүнсний ногоо, шахмал түлш байна.

3. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

START-UP гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг ажлын 14 хоногийн хугацаатай /2019-04-25-аас 2019-05-14-ны өдрийг хүртэл/ нийтэд хүргэх зар тавьж 8 иргэн бүртгүүлсэн байна.

4. Нийтлэг үйлчилгээний хүрээнд:

- АМЧБОЗӨ ганцаарчилсан зөвлөгөөг 185 иргэнд үүнээс 99 эмэгтэй, бүлгийн зөвлөгөө сургалтыг 361 иргэнд үүнээс эмэгтэй 230 өгч ажилласан байна.

- **Зорилтод өрхийн төгсөх ангийн сурагчдад АМЧБОЗӨ бүлгийн мэдээлэл хийв.**

Сайншанд сумын зорилтод өрхийн 9-12-р ангийн 7 сурагчдад сургалт хийлээ.Тус сургалтаар үнэ төлбөргүй суралцах боломжууд, тэтгэлэгт хэрхэн хамрагдах талаар, сургуулиудын мэдээлэл, ХХҮГ-с хэрэгжүүлж буй мэргэжил олгох сургалт, орон нутагт эрэлттэй байгаа ажил мэргэжлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ярилцлага өрнүүлэн асуултанд хариуллаа. Мөн МСҮТ-н багш Батбаяр оролцон насанд хүрэгчдийн 8 ангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч асуултанд хариуллаа.

5. Төсөв санхүүгийн хүрээнд:

ХЭДСанд нийт 34407121 төгрөг орсноос санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 33543121, ХБИ ажиллуулаагүйн төлбөр 864000 төгрөг. Өссөн дүнгээр нийт 67929121 төгрөг, үүнээс санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 61305121, ХБИ ажиллуулаагүйн төлбөр 6624 000 төгрөг байна. Эргэн төлөлтийг задалвал: Малжуулах 27236621 төгрөг /өссөн 41062621 төгрөг/, дэмжлэг 5702000 төгрөг /өссөн 16412500/,Ахмад 250000 төгрөг /өссөн 1125000/,ХБИ 354500 төгрөг /өссөн 2705000/байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:

№	Ажил үйлчилгээ	Биелэлт
1	Хүүхдийн ордны дэргэдэх “Отаку” клубээс санаачлан зохион байгуулж буй “Япон соёлын өдөрлөг”-ийг хамтран зохион байгуулах.	“Япон орны соёлыг сурталчлах мини”өдөрлөгийг 2019 оны 04 сарын 03-ны өдөр зохион байгууллаа, өдөрлөгөөр Япон орны тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах, үндэсний тоглоом, хувцас, аниме, манга зургийн үзүүлэнг гарган үе “ДАНОБ” Дорноговь аймнийн нэгдсэн отаку бүлгэмийнхэн үе тэнгийнхэндээ танилцууллаа. Өдөрлөгт нийт сайншанд сумын ЕБ-ын 4 сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 110 гаруй өсвөр үе, залуучууд хамрагдлаа.
2	“Өөрчлөлтийг өөрөөсөө” хөтөлбөрийн хүрээнд сонгож авсан ЕБ-ийн 1-р сургуулийн 10а ангийн сурагчдад хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Хөтөлбөрийн хүрээн 10а ангийн 30 сурагчдад “Зорилго ба мөрөөдөл”, Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгч сурагчдын нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгууллаа.
3	Хүүхэд хамгааллын жишиг сургуулийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах.	Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар зөвлөлийн комисс хуралдан сургуулийн удирдлагуудад мэдээлэл өгч ажиллаа. Хүүхдийн хөгжил, хамгааллын зөвлөл байгуулагдаагүй төлөвлөгөө гараагүй байгаа учир үйл ажиллагаа явагдаагүй.
4	АХНЗ, ХОБ-тай хамтран оролцооны байгууллагын өртөөчилсөн аяныг хэрэгжүүлэх.	ЕБ-ын 1-р сургуулийн хүүхдийн оролцооны “Өсвөрийн цагдаа”, “Өсвөрийн эмч”-ийн клубтэй аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийг уулзуулан хийгдэж буй болон цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санал бодлоо илэрхийлэн туршлага солилцлоо.
5	Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх цэцэрлэгийн насны хүүхдүүдэд “Гал хүү, Ус хүү” жүжигчилсэн тоглолтыг үзүүлэх.	Хүүхдийн оролцооны байгууллага, драмын 8 хүүхдийг хамруулан жүжгийн бэлтгэл ажил хангагдаж байна.

Эрүүл мэндийн газар:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц	
1	<p>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, туршлагаа харилцан солилцох зорилгоор "Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" ажил мэргэжлийн уралдаан, сургалтыг сумдын ЭМТ-үүд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүд оролцсон. Ажил мэргэжлийн уралдаанд ЭМТ-үүдээс багийн эмч, эх баригч, сувилагч, НЭМ-ийн ажилтнуудын эх хүүхдийн тусламж үйлчилгээний чадавхийг үнэлэх онол, гардан үйлдлээр мэдлэгийг шалган шалгарууллаа.</p> <p>Мөн "Эрүүл нярайн асаргаа"сэдэвт 1 багц цагийн сургалт, Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж буй эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах "Жирэмсэн ба зүрх судасны өвчин" цахим сургалтыг нарийн мэргэжлийн эмч нар болон анхан шатны 10 эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эх баригч нарыг хамруулав.</p>
2	<p>"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 24 сараас 12 нас хүртэлх насны хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчлэн эрүүлжүүлэх цогц тусламж үйлчилгээ"-г сонгон шалгаруулалтын зохион байгуулан, 5 шүдний үүдэн эмнэлгийг хамруулав. Амны хөндийн эрүүл мэндийн кабинетийн сургалтын хуваарийг батлуулж, Сайншанд сумын цэцэрлэгүүдэд сургалтын хуваарийг хүргүүлсэн. Нийт 34 удаагийн сургалтанд 8, 9-р цэцэрлэгийн 514 хүүхэд, 190 эцэг эхийг хамруулж, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгосон.</p> <p>"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах, эцэг эхчүүдийн амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүүхдийн байгууллага, орон нутгийн удирдлага, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа өдөр Сайншанд төв талбайд зохион байгуулагдан 9, 3, 11, 13-р цэцэрлэг болон 1-р сургуулийн сурагчдийн урлагийн тоглолт болон холбогдох байгууллага, мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхэд, эцэг эхчүүдэд амны хөндийн эрүүл мэндээ сахих зөвлөгөө өгч, сурталчилгаа хийсэн. Өдөрлөгт нийт 200 гаруй хүүхэд, эцэг эхчүүд хамрагдсан.</p> <p>"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" аймгийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг батлуулж, төсөл, төлөвлөгөөг боловсруулж байна. "Эрүүл шүдтэй хүүхдийн байгууллага, анги, хамт олон" шалгаруулах болзолт уралдааны удирдамж гаргасан.</p>
3	<p>Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээнд хийж үнэлгээг хийж, сүүлийн 4 жилийн байдлаар гарган, ЭМЯ-руу хүргүүлэв.</p>
4	<p>Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны 2018 оны гүйцэтгэлийн тайланг гарган ЭМХТ-ийн эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанд хүргүүлэн ажиллаа. Хачигт энцефалитаас сэргийлэх вакциныг талаарх сургалтыг Онцгой</p>

	<p>байдлын газрын 50 албан хаагчдад хамруулсан.</p> <p>Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг олгох сургалт-ЕБСийн ахдах ангийн сурагчдад “Элэг бүтэн Монгол”, “Зөв зохистой хооллолт”, “БЗДХ-ын өнөөгийн байдал, зонхиолон тохиолдох халдвар” сэдэвт сулгалтанд Цахилгаан түгээх станц, Цагдаагийн нийт 68 албан хаагчийг хамруулсан.</p>
5	<p>“Нярайн асаргаа ба хөхний сүүний ач холбогдол”, “Бэлгийн замаар дамжих халдвар, түүнээс урьдчилан сэргийлье” “Дархлаажуулалтын ач холбогдол гэсэн сэдвээр жирэмсэн эхчүүдэд зөвлөгөө өгч, 31 жирэмсэн эхийг хамруулав.</p> <p>Сайншанд сумын цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, МСҮТ-ийн дотуур байрны хүүхэд, Сайншанд сумын 6 багийн иргэдэд “Тамхины хор хөнөөл” сэдвээр сургалт зохион байгууллаа. Нийт 83 хүн хамрагдсан.</p>
6	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны хэрэгцээнд нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тухай ЭМ 01/19 дугаар тендерт шалгарсан 4 багцад эм ханган нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн газрын даргын А/47 дугаар тушаалаар баталгаажуулан нэгдсэн эмнэлгүүдэд хүргүүлсэн. Ерөнхий гэрээгээр 13 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төвд 4.356.000 төгрөгний В, С вирусын оношлуурын захиалгыг хийж, худалдан авсан.</p>
7	<p>“Ажлын байрны дасгал хөдөлгөөн” сарын аяны хүрээнд ЕБ-ын 4 сургуулийн 64 бүлгийн 114 хүүхдэд Хичээлийн завсарлагаанаар хийх дасгал, 9 албан байгууллагын 22 хүнд Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тус тус зааж сургасан.</p>
Цаг үеийн ажлын явц	
1	<p>Орон нутгийн төрийн захиргааны удирдлагагууд, бүх сумдын болон багуудын засаг дарга нар, ЭМБ-уудын ажилтнуудад “БЗДХ/ДОХ/ХДХВ-ийн өнөөгийн байдал, халдварын тархалтыг бууруулах салбар дундын хамтын ажиллагаа” сэдэвт нөлөөллийн уулзалтыг зохион байгуулах төсөл, төлөвлөгөг боловсруулж байна.</p>
2	<p>Хатанбулаг сумын Агрут багийн нутаг дэвсгэрт гарсан мал амьтны гоц халдварт шүлхий өвчний голомтын болон сэжигтэй бусэд амьдарч байгаа иргэд, ажиллаж байгаа төрийн албан хаагчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавин, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.</p>
3	<p>Талст зам өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Пневмококкийн 3 цэнт вакцин, халдварт саагийн идэвхигүйжүүлсэн вакцин 2019 оны 04 сарын 01-нээс товлонд нэвтрүүлэхтэй холбогдуулан нээлт үйл ажиллагааг 4 сарын 11-нд зохион байгуулсан.</p>
4	<p>Геронтологийн үндэсний төвтэй хамтран “Эрүүл насжилттай төлөө-хамтдаа” ахмад настанд зориулсан үзлэг сургалтад 100 гаруй хүн хамрагдсан.</p>
5	<p>“Осол, гэмтлээс сэргийлэх тогтвортой хөгжил -2030” салбар дундын үндэсний чуулганыг угтаж “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” уриан дор өдөрлөг зохион байгуулан хэвлэлийн бага хуралд ЭМГ, аймгийн ЦГ-ын Замын цагдаагийн тасаг, Авто тээврийг үндэсний төвийн Дорноговь аймаг дахь салбар, аймгийн Нэгдсэн эмнэлэг</p>

	<p>хамтран оролцон мэдээлэл хийлээ.</p> <p>Осол гэмтэлд өртсөн хүүхдүүдийг эмчилж эдгэрүүлж байгаа эмч нарынхаа санал санаачлагаар эмч нар ард иргэддээ хариуцлагыг ухамсарлуулах зорилгоор “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” сэдэвт өдөрлөгт ЭМГ, аймгийн НЭ, УАУРСТ, ӨЭМТ-үүд, хувийн эмнэлгүүдийн нийт 120 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд дуу хоолойгоо нэгтгэн, Сайншанд сумын төв талбайд осол, гэмтлээс сэргийлэх уриалга, улаан өнгийн анхааруулга тэмдэг бүхий лоозон барьж жагслаа. Мөн аймгийн хэмжээний 13 сумын ЭМТ-үүд нэг өдөр нэг цагт уг өдөрлөгийг зохион байгуулсан</p>
6	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сумын эмч, мэргэжилтэнүүдийн холбоо, Глобаль сан хамтран зохион байгуулсан “Монгол улсад зонхилон тохиолдох халдварт өвчний үед эрүүл мэндийн анхан шатны түвшинд үзүүлэх нэн шаардлагатай тусламж үйлчилгээ” сэдэвт 3 хонгийн сургалтанд хамрагдав.
7	Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажиллав. Мөн тус сумдын ЕБС-ийн сургуулийн сурагчдад " Амны хөндийн эрүүл ахуй", " Шүд угаах арга техник", " Бэлгийн замаар дамжих халдвар" сэдвээр, Цэцэрлэгийн хүүхдүүдэд “Шүд угаах арга техник” сэдвээр, Төрийн албан хаагч, эцэг эх асран хамгаалагчдад "Хүүхдийн осол гэмтэл, халуун тогооны хэрэглээг халъя", " Бэлгийн замын өвчлөл " сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.
8	2019 оны 04 сарын 04-ний өдөр Боловсрол сургалын академийн багш Н.Оюундалай “Эмнэлгийн ажилтны харилцаа хандлага” “Инээмсэглэл эерэг хандлага” сэдвээр сургалт зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын 120 ажилтан албан хаагч хамрагдлаа.
9	<p>Олон улсын сувилагчдын өдрийг угтаж нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд нийт 20 илтгэл бэлтгэн ирүүлснээс 8 илтгэлийг хэлэлцүүлснээс:</p> <p>1-байрт АНЭ-ийн үйл, оношийн тасгийн лаборант Т.Алтантуяагийн “Орон нутгийн түвшинд сүрьеэг эр илрүүлэхэд молекул биологын GeneXpert шинжилгээний ач холбогдол”,</p> <p>2-р байрт АНЭ-ийн амбулаторийн тасгийн эх баригч А.Шижирмаагийн “Умайн хүзүүний эс зүйн шинжилгээний өнөөгийн байдал”,</p> <p>3-р байрт АНЭ-ийн төрөх тасгийн эх баригч Х.Ундармаагийн “Ургын урьдчилсан жинг антропометрийн үзүүлэлтээр тооцон, бусад аргуудтай харьцуулсан дүн” илтгэлүүд тус тус шалгарлаа.</p>
10	АШУУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн судалгааны багтай хамтран “ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх судалгаа”-г 4 сум, 1 өрхийн ЭМТ-үүдэд хийж, нийтдээ 141 сонгогдсон үйлчлүүлэгчдээс анхан шатны тусламж

	үйлчилгээний чанар хүртээмж, сэтгэл ханамжийн судалгааг авав
11	Нийслэлийн яаралтай тусламжийн нийгэмлэгийн сургагч багш Б.Болдбаатар орон нутгийн телевизээр “Эмч зөвлөж байна” буланд хүүхдийн осол гэмтлээс гадны биетээр хахсан үед иргэд хэрхэн анхны тусламж үзүүлэх талаар зөвлөмж өглөө
12	Эрүүл мэндийн газрын дарга Г.Энхцэцэг АИТХ-ын 30 төлөөлчдөд “Хүн амын дунд зонхилох өвчлөл, нас баралтын шалтгаан, цаашид авах арга хэмжээ” сэдвээр мэдээлэл хийсэн.
13	Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Яаралтай тусламжийн цогц менежмент, Гамшиг ослын үеийн бэлэн байдал, төлөвлөлт” сэдэвт 2 багц цагийн сургалтыг 2019 оны 04 сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулж, төр ба хувийн хэвшлийн эмч мэргэжлтнүүдийг хамруулна
14	“Шинэ болон дахин сэргэж буй хадлдвар, зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээ” сургалтад 80 эмч мэргэжилтнийг хамруулсан.

Биеийн тамир спортын газар: 2019 оны 04 сарын 05-ны өдөр Дорноговь аймгийн хууль зүйн салбарын байгууллагуудын 3 төрөлт тэмцээн зохион байгуулагдаж, нийт 10 багийн 150 тамирчин оролцсон. 1-р байранд Хилийн 0108-р анги, 2-р байрандХилийн 0129-р анги, 3-р байрандХилийн 0168-р анги шалгарсан.

2019 оны 04 сарын 06-ны өдөр Дорноговь аймгийн Төрийн байгууллагуудын Удирдах албан тушаалтны 4 төрөлт тэмцээн зохион байгуулагдаж, нийт 12 багийн 180 тамирчин оролцсон. Багийн дүнгээр 1-р байранд Дорноговь аймгийн Засаг дарга Т. Энхтүвшин ахлагчтай 2-р баг,2-р байранд Сайншанд сумын Засаг дарга С. Одбаяр ахлагчтай 3-р баг,3-р байранд Замын-Үүд сумын Засаг дарга Н.Алдарбаяр ахлагчтай 4-р баг шалгарсан.

2019 оны 04 сарын 11-13-ны өдөр “Спорт-2019” боловсрол, соёл, урлагын ажилтнуудын тэмцээн спортын 7 төрлөөр 4 сарын 11-13 хооронд зохион байгуулагдаж, 26 багийн 645 тамирчин оролцсон.

Багийн дүнгээр 1-р байранд Б.Эрдэнэцэцэг захиралтай Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн баг,тамирчид, 2-р байранд Ц.Цабшир захиралтай АШУҮИСургуулийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн баг, тамирчид, 3-р байранд Д.Цэрэнлхам захиралтай Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баг,тамирчид шалгарсан.

2019 оны 04 сарын 20-21-ний хооронд 3х3 сагсан бөмбөгийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн явагдаж,52 багийн 208 тамирчин оролцсон. Эмэгтэй бага насанд Сайншанд сумын 4-р сургууль 3-р байр, Замын-Үүд сумын 3-р сургууль 2-р байр, Eagles баг 1-р байр, Эрэгтэй бага насандStorm баг 3-р байр, Өргөн сумын сургууль 1-р баг 2-р байр, Өргөн сумын сургууль 2-р баг1-р байр, Эмэгтэй ахлах насандСайншанд сумын 1-р сургууль 3-р байр, Сайншанд сумын 4-р сургууль 2-р байр, Skyball баг 1-р байр, Эрэгтэй ахлах насандSkyball баг 3-р байр, Цолмон баг 2-р байр, Замын-Үүд сумын 3-р сургууль 1-р байранд тус тус шалгарсан.

2019 оны 04 сарын 27,28-нд аймгийн ИТХурал, ЗДТГ, Биеийн тамир спортын газар, Монголын шатрын холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөл хамтран Монголын шатрын нэрт зүтгэлтэн, Монгол Улсын 6 удаагийн аварга, ОУ-ын шатрын холбооны мастер Жамбалдоогийн Лхагваагийн нэрэмжит говийн бүсийн аймгуудын холимог наснышатрын аварга шалгаруулах тэмцээнийгзохион байгуулсан. Тэмцээнд Дорноговь, Дундговь, Өмнөговь,

Говьсүмбэр аймгийн нийт 180 гаруй тамирчид оролцсон. Багийн нийлбэр дүнгээр 1-р байранд Дорноговь аймаг, 2-р байранд Өмнөговь аймаг, 3-р байранд Говьсүмбэр аймаг тус шалгарсан.

5-6 нас /эрэгтэй/

- 1- р байранд Б.Энхмөнх-Өмнөговь аймаг
- 2- р байранд Б.Энхбүрэн-Говьсүмбэр аймаг
- 3- р байранд Д.Дүүрэнбаяр-Дорноговь аймаг

5-6 нас /эмэгтэй/

- 1- р байранд Х.Номун-Дорноговь аймаг
- 2- р байранд Э.Шинэзаяа-Дорноговь аймаг
- 3- р байранд М.Энхмаа-Дундговь аймаг

7-8 нас /эрэгтэй/

- 1- р байранд Х.Дөлгөөн-Говьсүмбэр аймаг
- 2- р байранд П.Баяр-Эрдэнэ- Говьсүмбэр аймаг
- 3- р байранд Б.Санжаадамба- Өмнөговь аймаг

7-8 нас /эмэгтэй/

- 1- р байранд М.Маргад- Говьсүмэр аймаг
- 2- р байранд Э.Зол-Учирал-Дорноговь аймаг
- 3- р байранд Х.Аригун-Өмнөговь аймаг

9-10 нас /эрэгтэй/

- 1- р байранд Г.Тэнгүүндалай-Дорноговь аймаг
- 2- р байранд А.Батжав-Дорноговь аймаг
- 3- М.Занданшагай-Өмнөговь аймаг

9-10 нас /эмэгтэй/

- 1- р байранд Л.Анхилуун-Өмнөговь аймаг
- 2- р байранд О.Алдармаа Дорноговь аймаг
- 3- р байранд У.Уянгабилэг Дорноговь аймаг

11-12 нас /эрэгтэй/

- 1- р байранд П.Хангал-Дорноговь аймаг
- 2- р байранд Н.Эрхэмбаяр-Өмнөговь аймаг
- 3- р байранд Ө.Өсөх-Ирээдүй-Дорноговь аймаг

11-12 нас /эмэгтэй/

- 1- р байранд С.Энхмаа-Өмнөговь аймаг
- 2- р байранд Б.Цовоо-Говьсүмэр аймаг
- 3- р байранд Б.Маралжингоо-Өмнөговь аймаг

13-14 нас /эрэгтэй/

- 1- р байранд Б.Болорсүх-Говьсүмэр аймаг
- 2- р байранд А.Жавхлантөгс-Дорноговь аймаг
- 3- р байранд Б.Отгонбаяр-Өмнөговь аймаг

13-14 нас /эмэгтэй/

- 1- р байранд Т.Эмүжин-Өмнөговь аймаг
- 2- р байранд Б.Тайгаль- Дундговь аймаг
- 3- р байранд Билгүүнсүрэн-Дундговь аймаг

15-16 нас /эрэгтэй/

- 1- р байранд Э.Мөнхбаяр-Дорноговь аймаг
- 2- р байранд П.Тайванбаяр-Өмнөговь аймаг
- 3- р байранд Г.Түмэндэлгэр-Өмнөговь аймаг

15-16 нас /эмэгтэй/

- 1- р байранд Н.Мөнгөнсарнай-Говьсүмэр аймаг
- 2- р байранд Э.Энхбаяр-Дорноговь аймаг
- 3- р байранд Э.Энхмаа-Дорноговь аймаг

17-18 нас /эрэгтэй/

- 1- р байранд Н.Билгүүн-Өмнөговь аймаг
- 2- р байранд Э.Түвшинтөгс-Говьсүмбэр аймаг
- 3- р байранд Е.Шийрэвдорж-Дорноговь аймаг

17-18 нас /эмэгтэй/

- 1- р байранд А.Энхдэлгэр-Говьсүмэр аймаг
- 2- р байрд Ч.Удвал-Дундговь аймаг
- 3- р байранд А.Сэндмаа-Дорноговь аймаг

Насан хүрэгчид /эрэгтэй/

- 1- р байранд Б.Боорчи-Говьсүмбэр аймаг
- 2- р байранд Г.Оргил-Өмнөговь аймаг
- 3- р байранд О.Батзориг-Дорноговь аймаг
- 4- р байранд Б.Одонбаатар-Дорноговь аймаг
- 5- р байранд Б.Алтангэрэл Өмнөговь аймаг

Насанд хүрэгчид /эмэгтэй/

- 1- р байранд Э.Цэндсүрэн-Дорноговь аймаг
- 2- р байранд Г.Номин-Өмнөговь аймаг
- 3- р байранд Н.Дуламсүрэн-Дорноговь аймаг
- 4- р байранд Э.Одгэрэл-Дорноговь аймаг
- 5- р байранд Б.Өнөтуяа-Говьсүмбэр аймаг

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс:

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр: “Газрын тос боловсруулах үйлдвэр” төслийн хүрээнд Алтанширээ сумын нутаг дэвсгэрт 254 га газрыг улсын хэмжээний томоохон бүтээн байгуулалтын зориулалтаар нэмж улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох материалын хамт аймгийн ИТХ-аар оруулан хэлэлцүүлж, дэмжсэн тогтоолыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад баримтлах журам”-д Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тухайн шатны сумын Засаг дарга нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулсан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг өргөн барьсанаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал түүнийг хэлэлцэн батална гэсэн заалт болон Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т хууль тогтоомжид зөвхөн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглоно гэсэн заалтуудыг тус тус зөрчиж сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурал хэлэлцэн батлахаар тусгаж хууль зөрчсөн, хууль тогтоомж, журмаар зохицуулагдсан асуудлыг хуулбарлан боловсруулсан, 2016 оноос хойш мөрдөж ажиллаагүй тул аймгийн ИТХТХ-д санал оруулан хэлэлцүүлж хүчингүй болгуулсан.

-Үндэсний бүтээн байгуулалт, Төрийн гэрэгэ шагнал-д Дорноговь аймгийн 2018 оны томоохон бүтээн байгуулалт болох Мандах наран 1000 айлын орон сууц, сумдын дэд бүтэц, Багийн ИТХ, 500 хүний суудалтай спорт цогцолбор зэрэг олон бүтээн байгуулалтуудыг тодорхойлж холбогдох танилцуулга материалыг журмын дагуу бэлтгэн баримтжуулж, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мандах суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэг, Хатанбулаг сумын Соёл, спортын цогцолборын асуудлаар БСШУЯ-нд орон нутгийн нөхцөл байдлын талаар болон шийдвэрлэх санал хүсэлт хүргүүлсэн.

-Жайка ОУБ, Үндэсний хөгжлийн газар, БХБЯ хамтран хэрэгжүүлж буй “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах” төслийн багийнханаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 04 дүгээр сарын 18-ны өдөр Дорноговь аймгийн хөгжлийн асуудлууд сэдэвт хэлэлцүүлэг уулзалтыг Соёмбо цогцолборт зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт сум орон нутаг, агентлагийн удирдлага, мэргэжилтнүүд болон ИТХ-ын төлөөлөгчид, ТББ, хувийн хэвшил, ЖДҮ эрхлэгчид, иргэдийн төлөөлөл 31 хүн оролцож аймаг орон нутгийн хөгжлийн асуудлаарх саналаа дэвшүүлж хэлэлцсэн. Тус төслийн зүгээс хэлэлцүүлгүүдийг үе шаттай зохион байгуулж, төлөвлөлтөд талуудын тэгш оролцоог ханган ажиллахаар болсон.

-БСШУЯ-ны үйлдвэрлэлийн хэлтэс, Барилга хөгжлийн төвд Хатанбулаг, Дэлгэрэх сумын Соёл спортын төвийн асуудлаар удаа дараа албан бичиг хүргүүлсэний үр дүнд 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд БСШУЯ-наас байгуулагдсан ажлын хэсэг /Захиалагч, зураг төсөв зохиогч, гүйцэтгэгч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч болон аймгийн ГХБХБГ-ын төлөөлөл оролцсон/ сумдад нөхцөл байдлыг тодорхойлж ажиллалаа. 5 дугаар сарын 2-ны өдөр ажлын хэсгийн хурлыг бүх талуудыг оролцуулан Улаанбаатар хотод хийхээр төвлөсөн.

-АНУ-ын ЭСЯ-ны хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр багт баригдах 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөлд шаардлагатай мэдээлэл, материалыг бэлтгэн төслийн хариуцсан ажилтанд хүргүүлсэн.

- Барилгын ажил эхлүүлэхээр хүсэлт гаргасан 8 ААНБ-ын ирүүлсэн материалыг хянаж зөвшөөрөл олгож, 3 байгууллагад зөвлөмж өгсөн.

- Газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр 2015-2018 онд хийсэн ажлын тайланг бэлтгэж Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, эрхийн гэрчилгээ шилжүүлэх, газар өмчлөх эрх шилжүүлэх чиглэлээр гарсан аймгийн Засаг даргын 9 захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

- Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтран чөлөөт бүс дээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААНБ-уудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл зөвлөгөө өглөө.

- Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлэг, 320 хүүхдийн бага сургуулийн тендерийг Төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтаар ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг батлагдсан зураг төслийн дагуу бэлтгэж ОНӨГ-т яаралтай хүргүүлэх чиглэлийг аймгийн ГХБХБГ-т өгсөн.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр: Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 1-р улирлын байдлаар гарган ХШҮДАХ-т хүргүүлсэн.

- Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулахад хэлтсийн мэргэжилтнүүд хариуцсан ажлыг тухай бүрд шуурхай гүйцэтгэн ажилласан.

- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасны дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд ашиглалтанд орсон барилга, байгууламжийн мэдээг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлсэн.

- Мандах наран хорооллын гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч Чандмань-Илч ХХК-д 2018 оны ажлын санхүүжилтийн үлдэгдлээс олгосон.

- Аймгийн ОБГ-ын автомашины нийлүүлэгч Мэжик бонд ХХК-д санхүүжилтийг олгосон.

- Эрдэнэ сумын хог зөөврийн автомашины нийлүүлэгч Альянс трейд ХХК-д санхүүжилтийг олгосон.

- Үндэсний хөгжлийн газар, МУИС-ын эдийн засгийн хүрээлэн, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хэлэлцүүлгийг 2019.04.19-ний өдөр Сайншанд суманд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 14 сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, аймгийн агентлаг, байгууллагын дарга, ажилчид, Сайншанд сумын 7 багийн төлөөлөл нийт 200 гаруй иргэнийг хамруулсан.

- Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас 2019 оны 04 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Төв аймагт зохион байгуулсан Улсын төсвийн төлөвлөлтийн программын сургалтанд хэлтсийн ахлах мэргэжилтэн 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

- Тогтвортой амьжиргаа-3 төсөл, Дэлхийн банк, Сангийн яамтай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн 4, 5 дугаар модулын сургалтанд хэлтсийн ахлах мэргэжилтэн аймгийн чадавхи бэхжүүлэх багийн 2 гишүүний хамт хамрагдсан.

- Замын-Үүд сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын санхүүжилтийг авахаар холбогдох материалыг бүрдүүлсэн.

- Сайншанд сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын явцын гүйцэтгэл, Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний ажлын урьдчилгаа, аймгийн ЗДТГ-ын засварын ажлын урьдчилгаа санхүүжилтийг олгосон. Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн авто парк шинэчлэлт, Төмөр замын гармаас цэнгэлдэх хүрээлэн хүртэлх 0.5 км автозамын ажлын санхүүжилтийг олгосон.

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/257 дугаар захирамжаар “Аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн системд бүртгэлтэй тусгай хамгаалалттын газар нутгийн мэдээлэлтэй тулгаж нэгдсэн мэдээллийн санг цэгцлэх” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар аймаг, сумдын хүчин төгөлдөр тусгай хамгаалалттай газар нутгийн тогтоолуудад хяналт шинжилгээ хийж, аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийг Ашигт малтмал, Газрын тосны газрын кадастрын бүртгэлийн системтэй тулгалт хийсэний үндсэн дээр хугацаа дуусаж байгаа-13 газар, кадастрын бүртгэлийн системд бүртгэгдээгүй-8, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай 5-н газрын зөрчлийг арилгаж дахин тусгай хамгаалалтад авах, шинээр авах-1, нийт 27 газрыг аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлаж Ашигт малтмал, Газрын тосны газар болон Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 7 өргөдлийг хянаж, 5 өргөдлийг Ашигт малтмал, Газрын тосны газрын цахим сүлжээнд бүртгэж, 2 өргөдөлд татгалзсан хариу өгсөн.

БОАЖС-ын санаачлагаар хэрэгжиж буй Ногоон паспорт эзэмшигч хүүхдүүдийн уулзалт 2019 оны 04 дүгээр сарын 06-11 өдрүүдэд Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт зохион байгуулагдсан. Уулзалтад , Боловсрол, соёл урлагын газар, БОАЖГ, Ерөнхий боловсролын 1 сургуулийн эко клубын багш, 7 сурагчийн хамт хамрагдсан.

2019 оны 04 дүгээр сарын 09,10 өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгуулагдсан Биологийн олон янз байдал, “Био аюулгүй байдал хамгаалалт” сэдэвт зүүн бүсийн сургалтад тус аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Гаалийн газар, МХГ, БОАЖГ-ын нийт 8 мэргэжилтэн оролцсон.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон нээлттэй нийгэм форумаас зохион байгуулсан орон нутаг дах хамтын ажиллагааны гэрээ, зохицуулалт, хэрэгжилт үр нөлөө сэдэвт 2 өдрийн сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан.

Мөн БНХАУ-ын Бээжин хотод Цайны зам ОУАЖНхолбооны 3 орны 5 нутгийн нэгдсэн уулзалтад 2 мэргэжилтэн оролцож цаашид аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар харилцан санал солилцсон.

Солонгос Монголын хамтарсан Ногоон-Ази сан Цөлжилтийн судалгааны баг Сайншанд сумын Зүүнбаян багт ажиллаж судалгааны хийсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

- Аймгийн тариалан эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөн зохион байгууллаа. Нийт 70 гаруй тариаланчид оролцсон. Сургалт, зөвлөгөөний үеэр монгол улсад атар газар эзэмшиж, газар тариалангийн салбар биеэ даан хөгжсний түүхт 60 жилийн ойг угтан “Тариаланчид дуулж байна” аймгийн анхдугаар уралдааныг явуулсан.

- Өрхийн хэрэгцээг өөрийн хашаанаас төслийг хэрэгжүүлэх, Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд Сайншанд сумын хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан нийт 6 иргэнд 4*3 харьцаатай хүлэмж олгох батламж гардуулсан. Эдгээр иргэд нь хашаандаамэргэжилийн байгууллагын заавар, зөвлөмжийн дагуу хүнсний нарийн ногоо тарих юм.

- 2019 онд аймгийн хэмжээнд шаардлагатай төмс, хүнсний ногооны үр татан авах санхүүжилтийг эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр олгох шийдвэрийг гаргуулсан.

- Малын эрүүл мэнд аймгийн дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулсан.

- Аймгийн аварга малчин шалгаруулах журамд өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулсан.

- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хүчингүй болгох шийдвэр гаргуулсан.

- Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах олон улсын өдрөөр аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөөх газарт хүргүүлсэн

- Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулсан

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 40 дүгээр тогтоол “Журам батлах тухай”-оор батлагдсан “Дорноговь аймагт худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудад мөрдөх журам”-ыг хүчингүй санал, үндэслэлийг боловсруулан ИТХ-д хүргүүлсэн.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 55 дугаар тогтоол “Жишиг үнэ тогтоох”-оор батлагдсан “Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнийн жагсаалт”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 61, 62 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэн ИТХ-д хүргүүлсэн.

- “Мал эмнэлгийн ажил үйлчилгээний үнийн жагсаалт”, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэ төлбөргүй, оюутан, сурагчдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах журам”төслийг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХурлаар батлуулсан.

- Мөн аймгийн тусгай хамгаалалтад байх хугацаа дуусах 13 газар, ашигт малтмалын кадастрын бүртгэлд бүртгэгдээгүй 13 газар, Зээгийн хөтөл орчмын 5817 га талбай нийт нэр бүхий 27 газрыг АИТХ-аар хэлэлцүүлж 30 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хамгаалалтад авсан. Тогтоолын холбогдох дээд шатны байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорноговь аймагт худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудад мөрдөх журам”-ыг хүчингүй болгуулсан.

- Сogтyууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хүчингүй болгох шийдвэр гаргуулсан.
- Аймгийн хэмжээнд 2019 оны хаврын тариалалтад шаардагдах төмсний элит үр татан авахад шаардагдах 5.0 сая төгрөгийг эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр олгох шийдвэр гаргуулсан.
- Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч дэд хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.
- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг сумдаас авч холбогдох газруудад хүргүүлсэн.
- Үүрэн холбооны газруудтай “Масс мессеж” үйлчилгээний гэрээг шинэчлэн хийсэн.
- Нийтлэг үйлчилгээний газартай хамтран малчин, мал бүхий иргэдэд аймгийн нөөцөд татан авсан өвсийг тухай бүрт олгон ажиллаж байна.
- Аймгийн Засаг даргын 2019 оны А/355 дугаар захирамжаар Дорноговь аймагт үйлдвэр, үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг батлуулан холбогдох газруудад хүргүүлсэн. ЖДҮ-ийг дэмжих санд 1.0 тэр бум төгрөг хуваарилах шийдвэр гарсан ба тус сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам Хууль зүйн яаманд бүртгүүлэн, төрийн мэдээлэлд хэвлэгдэх шатандаа явж байна.
- Аймгийн Засаг даргын 2019 оны А/352 дугаар захирамжаар “Дорноговь аймгийн шигшмэл хурд -2019” хаврын бүсийн уралдааныг Сайншанд суманд 2019.05.05-ны өдөр зохион байгуулах шийдвэрлэсэн.
- Шинэ хөдөө төслийн хүрээнд тус аймгийн 8 суманд тус бүр 2 нийт 16 мал угаалгы ванн шинээр барих шийдвэр гарсан ба тендерийн материал, зураг төсвийг бэлтгэх холбогдох газарт хүргүүлсэн.
- Аймгийн хэмжээнд хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор хашаандаа ногоо тарих сонирхолтой өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй нийт 6 иргэнд иж бүрэн 3*4 хэмжээтэй БНСУ-д үйлдвэрлэсэн хүлэмжийг олгохоор шийдвэрлэсэн. Мөн ХХААХҮЯ-наас урт хугацаатай, хүү багатай хөнгөлөлттэй зээлд зээлтд нийт 10 иргэнийг хамруулсан. Дээрх 16 хүлэмжийг нэгдсэн журмаар татах авах гэрээ, тээвэрлэлийн асуудлыг шийдвэрлэсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөг холбогдох газруудад хүргүүлэн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах, химийн бодисын савыг ахуйн хэрэглээнд ашиглахыг зогсоох арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон.

Зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 48-р тогтоолоор Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан, Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад баригдсан ЦДАШ, Дэд станцуудыг мэргэжлийн байгууллага болох БЗӨБЦТС ТӨХК-д шилжүүлэн өгөх шийдвэр гарсан. Уг шийдвэрийн дагуу Замын-Үүд суманд байршилтай ЦДАШ, дэд станцыг шилжүүлэн өгөх ажлын хэсэгт орж 2019.04.03-ний өдөр Замын-Үүд суманд ажилласан.
- Дорноговь Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын талбайд гэрэлтүүлэг хийх ажлын даалгавар, Цагдаагийн газрын уулзвараас хамарын хийд явах замын төлбөр хураах цэг хүртэл автозамын гэрэлтүүлэг хийх ажлын даалгавар, Сайншанд сумын 2, 3, 6-р багийн авто зам дагуу гэрэлтүүлэг шинээр хийх ажлын даалгаврыг тус тус боловсруулан ОНӨГ-т өгсөн.
- Иргэн төвтэй төрийн үйлчилгээ-2019 зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэгт хувиарлагдсан чиг үүргийн дагуу ажиллаж, зөвлөгөөнд хамрагдсан.

Хууль эрхзүйн хэлтэс:

Бүх нийтийн Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран аймгийн хэмжээнд 65 Эрх зүйн хөтөч бэлтгэн, эрх зүйн сургалт, сурталчилгааг иргэдийн хэрэгцээнд тулгуурлан шинэлэг арга хэлбэрээр зохион байгууллаа. Энэ сургалтанд 14 сум тус бүрээс ЗДТГ-ын Хууль, зүйн мэргэжилтэн, ЕБС-ийн Нийгмийн ажилтан, Насан туршийн боловсролын багш, сумдын Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн гэсэн 4 хүн, мөн харьяа агентлаг Цагдаагийн газар бусад Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийт 65 хүн эрхлэх асуудлын хүрээнд мэргэшсэн эрх зүйн хөтөч болох сертификатын сургалтанд хамрагдаж “Эрх зүйн хөтөч” сертификат гардууллаа.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсруулах явцад иргэн, олон нийтийн оролцоог хангаж, саналыг тусган ажиллаж байна.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 сарын 08-ны өдрийн 10/29 дугаар тогтоолоор “Нийтийн тээврийн хэрэгслээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэ төлбөргүй, окутан сурагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах журам”, 10/30 дугаартай тогтоолоор “Мал эмнэлгийн ажил үйлчилгээний төлбөрийн үнэ тогтоох” журмыг тус тус батлуулсан. Дээрх захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг боловсруулахад Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулж иргэдийн оролцоог хангаж, орон нутгийн иргэдийн саналыг тусгаж ажилласан.

Өргөн, Эрдэнэ сумдын Засаг даргын захирамжийг хянаж хуульд нийцүүлэх зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 сарын 07-ны өдрийн А/253 дугаартай захирамжаар Иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх, орон нутгийн бодлого шийдвэрийг сурталчлах зорилгоор Сайншанд Замын-Үүд сумын багийн хөгжлийн төвд мэдээллийн самбар байршуулахад 2860 000 төгрөгийг шийдвэрлэсэн. Мэдээллийн самбарыг дээрх 2 суманд хүлээлгэн өгч сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн Дорноговь аймаг дахь салбарын ажлын байранд орон нутгийн төсвөөс 4.5 сая төгрөгийг зарцуулан засвар, үйлчилгээ хийж ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан бөгөөд Хууль зүйн туслалцааны төвд ажиллах Өмгөөлөгчийн тоог нэмэгдүүлж иргэдэд хууль, эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй шуурхай хүргэхээр ажиллаж байгаа бөгөөд дээрх төвийн нээлтийг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хийсэн.

Дээрх арга хэмжээнд аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, Хууль зүйн туслалцааны үндэсний төвийн захирал Т.Уранболор, Төрийн захиргааны газрын дарга Д.Наран-Отгон зэрэг холбогдох албаны хүмүүс хүрэлцэн ирж нээлтийн үеэр Хууль зүйн туслалцааны үндэсний төвийн Өмгөөлөгчид иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан төлбөрийн чадваргүй 9 иргэнд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үйлчилсэн.

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2019 оны А/215 дугаартай захирамжаар батлуулан ажиллаж байна. Мөн Авилгатай тэмцэх газраас Дорноговь аймагт ирүүлсэн 8 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн. 2019 оны эхний 4 сарын байдлаар төрийн албан хаагчийг хуульд заасан үндэслэлийн дагуу ажлаас халсан, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, хууль бус төлбөр хураамж, Худалдан авах ажиллагааг хууль бусаар явуулснаас төсөвт хохирол учруулсан байдал тохиолдол гараагүй болно.

Төрийн албан хаагчдын дунд авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх арга хэмжээг Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Аймгийн Санхүүгийн аудитын газартай хамтран төрийн албан хаагчдын дунд “Авилга миний нүдээр” эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулсан. Уг уралдаанд эхний 3 байрт шалгарсан М.Ганбаатар, Ё.Болормаа, Х.Хүрэлмаа нарт Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” /2016-2020/үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасны дагуу 2018 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчилгээ үзүүлэх “Түр хамгаалах” байрыг шийдвэрлэсэн.

2018 оны 12 дугаар сард аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор “Төсвийн тодотгол” оор тус байрны засвар үйлчилгээний 10,000,000 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/238 дугаартай захирамжаар телекамер 4,726,000 төгрөг, Дорноговь их хөгжил сангаас тавилга хэрэгцээт зүйлсэд 20,000,000 төгрөг нийт 37,726,000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Хамгаалалтын байрыг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ашиглалтанд оруулсан. Одоогийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн зөрчлийн хэргийн эмэгтэй хохирогч 2, бага насны эсрэг хүчиндэх гэмт хэргийн хохирогч 1 эмэгтэй хүүхэд тус байранд хамгааллын үйлчилгээ аваад байна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбоотойгоор ХЗДХЯ-ны харьяа хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын Төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг анх удаа Сайншанд суманд 2019 оны 04 дүгээр сарын 4,5-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэс, Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн харьяатын газар, Хууль зүйн туслалцааны төв, Хилийн 0108 дугаар анги, Хилийн 0129 дүгээр анги, Хилийн 0168 дугаар анги, Сумдын Засаг дарга, Сумдын ЗДТГ-ын Хууль зүйн мэргэжилтнүүд зэрэг 280 төрийн албан хаагч оролцлоо.

Дээрх зөвлөгөөнд Төрийн албаны зөвлөл, Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Архивын ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудын төлөөлөл хүрэлцэн ирж Төрийн албаны болон шүүхийн шинжилгээний байгууллагын шинэтгэл, Авилгаас ангид, сайн засаглалыг бэхжүүлэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд болон Улсын хил хамгаалалтад Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь, Бүх нийтийн эрх зүйн

боловсролыг дээшлүүлэхэд Төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо зэрэг сэдвээр мэдээлэл өгсөн.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин Дорноговь аймагт Хууль, эрх зүйн салбарын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл өгч мөн Төрийн албан хаагчдад холбогдох үүрэг чиглэлийг өглөө.

Зөвлөгөөн 2 өдөр үргэлжилж эхний өдрийн арга хэмжээ Хилийн ангиудын авьяаслаг албан хаагчдын “Хилчдийн жавхаа” урлагийн тоглолтоор өндөрлөсөн бол 2 дахь өдөр нь Төрийн албан хаагчдын дунд тусгай хөтөлбөрөөр спортын өдөрлөг зохион байгуулж Гар бөмбөгийн тэмцээний төрөлд 1 дүгээр байранд Хилийн 0108 дугаар ангийн албан хаагчид, 2 дугаар байранд Хилийн 0129 дүгээр ангийн албан хаагчид, 3 дугаар байранд Хилийн 0168 дугаар ангийн албан хаагчид, Буухиа тэмцээний төрөлд 1 дүгээр байранд Хилийн 0108 дугаар ангийн албан хаагчид, 2 дугаар байранд аймгийн Цагдаагийн газар, 3 дугаар байранд Хилийн 0129 дүгээр ангийн албан хаагчид, Олс таталтын тэмцээний төрөлд 1 дүгээр байранд Хилийн 0108 дугаар ангийн албан хаагчид, 2 дугаар байранд Хилийн 0129 дүгээр ангийн албан хаагчид, 3 дугаар байранд Хилийн 0168 дугаар ангийн албан хаагчид шалгарч багийн нийт дүнгээр Хилийн 0108 дугаар ангийн албан хаагчид шилжин явах цом, 1 сая төгрөгөөр шагнууллаа.

Дээрх 2 өдрийн зөвлөгөөний арга хэмжээг хааж аймгийн Засаг дарга үг хэлэхдээ Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг 2 жил тутамд зохион байгуулж байхаар шийдвэрэлэснээ мэдэгдлээ.

Мөн Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр хэвлэгдсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд, Хууль зүйн үндэсний хүрээлэн, АТГ-аас ирүүлсэн бусад ном товхимол, гарын авлагыг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд бүртгэлээр тараан өгсөн.

Монголын Хуульчдын холбооноос Хуульчийн 2019 оны үргэлжилсэн сургалтын 3 багц цагийн сургалтыг 2019 оын 04 дүгээр сарын 15, 16-ны өдөр зохион байгуулсан.

Мөн 2019 оны 04 сарын 16-нд 14 сумын Хууль зүйн мэргэжилтэн нарыг чадахжуулах, шинэ мэдээлэл өгөх зорилгоор 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтаар хууль зүйн мэргэжилтэн нарт аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Эрүүл мэндийн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба зэрэг байгууллагуудын холбогдох мэргэжилтэн нар мэдээлэл хийж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Хууль зүйн мэргэжилтэн нарыг Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн багц сургалтанд хуульчдийн хамт хамрагдсан.

Улсын бүртгэлийн эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан УБЕГ-аас орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилт бүхий сургалтыг 4 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд “Иргэн

төвтэй төрийн үйлчилгээ” сэдэвт сургалт зохион байгуулагдсан бөгөөд нийт 28 албан хаагч хамрагдсан.

Улсын бүртгэлийнэ хэлтэс нь Онцгой байдлын хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан дэслэгч Ч.Өнөрзулыг урьж “Ахуйн хэрэглээний химийн бодис, материалын зохистой хэрэглээ”, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах” сэдвээр сургалт авсан байна.

Архивын тасаг: Архивын тасгаас 2019 оны 04 сард хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, Хууль эрх зүйн хэлтсийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 28 ажлыг хийхээр төлөвлөж, 83 хувьтай биелүүлсэн байна. Архивын тасаг нь 39 албан бичиг хүлээн авч, 22 байгууллагад 13 албан бичиг явуулсан.

“Дорноговь аймгийн төрийн архивын сан хөмрөгт 2019 онд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын график”-ийг батлуулж, 38 байгууллагад аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны 04 сарын 24-ний өдрийн 3/677 тоот албан бичгээр хүргүүлээ.

Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Биеийн тамир спортын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын 2 дугаар хурлыг төлөвлөгөөг гаргаж, 11 байгууллагын 27 тоо бүртгэлийн баримт бичгийг комиссын гишүүдээр хянуулж, саналыг авч нэгтгээд байна.

Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дэргэдэх “Байгууллагын архивын баримтыг гэрээгээр цэгцлэх Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, Иххэт, Улаанбадрах сумдын Эрүүл мэндийн төвийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгах ажил хийж, данс бүртгэлийг үйлдээд байна. Аймаг, сумдын 12 байгууллагаас хэвлэмэл хуудасны захиалгыг хүлээн авч, Нийтлэг үйлчилгээний газарт хүргүүлэн, 11 байгууллагын 4 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж, 2820 хуудас хэвлэх зөвшөөрөл олгов.

Аймгийн Архивын тасагт 68 иргэн, 2 байгууллагаас өргөдөл, хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 29 архивын лавлагаа, тодорхойлолт олгож, 50 иргэнд 129 архивын баримтын хуулбар олгож үйлчилсэн.

“Дорноговь аймгийн төрийн архивын сан хөмрөгт 2019 онд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын график”-ийн дагуу Сайншанд сумын 5 дугаар цэцэрлэгийн 1986-2014 оны байнга хадгалах хадгаламжийн нэгжийг хүлээн авч, 1984-2014 оны даргын тушаалыг цахим хэлбэр шилжүүлэн, төрийн архивын программд шивэх ажил хийгдэж байна.

Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д Архивын тасгийн дарга оролцож, Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэг явуулах асуудлаар чиглэл авсан.

Сайншанд сумын 5 дугаар цэцэрлэг, Мандах, Хатанбулаг сумдын ИТХ-ын 2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Устгах хэргийн актыг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй Материал техникийн хангамжийн удирдах газрын 1964-1988 оны архивын баримтад эрдэм шинжилгээний техник боловсруулалт хийж, данс, бүртгэлийг шинэчлэн үйлдэв. Архивын тасгийн цахимжуулалтын ажлын сарын мэдээг Архивын ерөнхий газарт хүргүүлж ажиллаа.

Санхүү, төрийн сангийн хэлтэс:

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 37 төсөвт байгууллагын данс, 37 нэмэлт төсвийн данс, 25 сангийн данс нийт 99 дансны зарлагын гүйлгээг програмд шивэж төв төрийн санд дамжуулж, төлбөрийн баримтын архивын нэгж үүсгэн ажиллаж байна. Төсөвт байгууллагуудын 3-р сарын мэдээ, зарцуулалтын эрхийн хүсэлт баталгааг хүлээн авч хянаж баталгаажуулсан. Сумдын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд e-report системээр хяналт тавьж алдаа зөрчлийг залруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтээр зөрчилгүй санал дүгнэлт авч ажилласан. Ахмадын сан нээлгэх хүсэлт ирүүлсэн төсвийн байгууллагын хүсэлтийг үндэслэн төрийн санд бүртгэлийн данс нээлгэх хүсэлтийг хүргүүлж ажилласан.

Орлоготой уялдуулан төсвийн байгууллагуудын санхүүжилтийг эрэмбэлэн олгож байна. Нэмэлт санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 73 тушаалыг үндэслэн 10 удаагийн хүсэлтээр 15.6 сая төгрөгийн баримтын бүрдлийг хянаж нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж эрх нээсэн баримтыг архивын нэгж үүсгэн ажиллаж байна. Төсвийн байгууллагуудаас ирүүлсэн ахмадын сангийн зарцуулах хүсэлтийг үндэслэн 3 удаагийн хүсэлтээр 4.8 сая төгрөгийн хүсэлтийг Сангийн яаманд цахимаар хүргүүлж эрхийг нээлгэж ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангаас 150 сая төгрөгийн Мандах наран хорооллын гадна шугам сүлжээний ажлын санхүүжилтийг олгосон. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэр баясах зам ХХК 200.0 сая төгрөгийн авто замын гүйцэтгэл, Чандмань Илч ХХК 100.0 сая төгрөг авто парк шинэчлэлтийн ажлын санхүүжилт, Гом Илч ХХК 80 сая төгрөг Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр ус татах шугамын өргөтгөлийн урьдчилгаа санхүүжилт, Эм Ти Эм Жи ХХК Аймгийн засаг даргын Тамгын газрын засварын урьдчилгаа 41.0 сая төгрөг нийт 421 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Боловсрол шинжлэх ухааны сайдын эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн Өгөөмөр шанд ХХК 320 хүүхдийн сургууль барих ажлын 985.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Хэлтэст нийт 79 бичиг ирсэнээс 71 бичгийг албан хэрэгцээнд 5 бичгийн хариуг хүргүүлж 3 бичиг шилжүүлсэн байна. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Татварын хэлтэс: Улс ба орон нутгийн төсөвт 2170893.3 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 8 төрлийн нийт 3839 татварын тайлан, 3 төрлийн нийт 850 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Тайлант сард нэг уэгийн үйлчилгээний өрөөгөөр утсаар болон биечлэн 2303 татварт төлөгчдөд татварын хуулийн болон Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийлээ. Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 10 хуулийн этгээд болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн 5 татвар төлөгчдийн мэдээллийг хүлээн авч, НӨАТ төлөгчөөр шинээр бүртгэгдсэн 3 татвар төлөгчийн мэдээллүүдийг баазад тухай бүр шивж оруулан шинээр үүсэж байгаа татвар төлөгчдөд татварын багц хуулиар зөвлөгөө өгч ажиллалаа. НӨАТ суутган төлөгчийн тоо -345 үүнээс пос 315 шинээр 2 иргэн пос хэвлэж нэмэгдсэн мөн .төлбөрийн баримт олгоогүй болон олгосонч илгээгээгүй төлөвтэй 13 татвар төлөгчдөд шаардлага гардуулан ажилласан.

Татварын хэлтсийн даргын баталсан удирдамж болон татвар төлөгчөөс хасагдах хүсэлтийн дагуу 13 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулсан.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нуугдмал орлогын эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 6 байгууллагаас 725,18 сая төгрөгийн 32 мэдээллийг цуглуулж нэгтгэн тасгуудыг мэдээллээр ханган ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 22 төлбөр төлөгчөөс 7 төлбөр төлөгчийн 38,7 сая/төг-ийг хэсэгчлэн барагдуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай тооцоо нийлж ажиллалаа.

Хугацаандаа татвараа төлөөгүй 1 татвар төлөгчийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд, 2 татвар төлөгчийг Замын-Үүд сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэгт шилжүүлсэн.

Үндэсний хөгжлийн газар, аймгийн ЗДТГ, МУИС-ийн эдийн засгийн хүрээлэн, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслөөс хамтран зохион байгуулсан Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг зөвлөлдөх уулзалтанд 2 албан хаагч, Сайншанд сумын Соёмбо цогцолборт ХАБЭА-н тухай хууль, холбогдох дүрэм журмын талаар зохион байгуулж байгаа сургалтанд 1 албан хаагч тус тус оролцож байна.

Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус хэлтэст шинэчилсэн Төрийн албаны тухай хуулийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 2 дахь хэсэгт заасны дагуу 41 албан хаагчийн ажлын байранд ажлын байрны шинжилгээг хийж, шинжилгээг ярилцлага, санал асуулгын хэлбэрээр авч ажилласан.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

1. “Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц”

- Албаны дарга аймгийн Засаг даргатай 2019 оны төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. “Цаг үеийн ажлын мэдээлэл”

- Аймгийн Засаг даргын баталсан СХААлбаны 2018 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 14 тоот удирдамжийн дагуу “Чандмань илч ОНӨХХК-ний 2016-2017 онуудын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байсныг МУ-ын Сангийн Сайдын 2019 оны 01-р сарын 02-ны өдөр баталсан “Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд хийх шалгалтын удирдамж”-ийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхээр болсонтой холбогдуулан 2019.01.28-ны өдрийн 22 тоот албан бичгээр хяналт шалгалтыг зогсоосон тухай СХААлбаны 2019.03.22-ны өдрийн 68 тоот албан бичиг хүргүүлж, 2019.03.25-ны өдрөөс хяналт шалгалт үргэлжлүүлэн гүйцэтгэж, шалгалтын дүнгийн хурлыг 2019.04.22-ны өдөр Чандмань Илч ХХК-ний нийт ажилчдын дунд хийж, шалгалтын тэмдэглэлийг хүргүүлээ.

Эрүүл ажлын байр үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу албаны ажилтнууд өдөр бүр ажлын байран дахь дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн.

“Иргэн төвтэй төрийн үйчилгээ-2019” төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний сургалтанд дотоод аудитор Д.Отгон, Д.Отгонбаяр, архив бичиг хэргийн эрхлэгч Т.Анхчимэг нар хамрагдав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал сарын аян болон Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн нээлтийн үйл ажиллагаанд бүх албан хаагчид оролцов.

Аймгийн Төрийн албаны зөвлөлд Төрийн захиргааны албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 тогтоолын дагуу ажилчдын хувийн хэргийг шинэчиллээ.

Хөрөнгийн биржээс зохион байгуулсан Үнэт цаасны нээлттэй өдөрлөгт архив бичиг хэргийн эрхлэгч Т.Анхчимэг хамрагдав.

Аймгийн нийт төрийн албан хаагчдын дунд аймгийн ЗДТГазартай хамтран зохион байгуулсан Эссэ бичлэгийн уралдаанд нийт 52 бүтээл ирүүлснээс Дэлгэрэх сумын ЕБС-н захирал М.Ганбаатар 1-р байр, Сайхандулаан сумын Цаг уур, орчин шинжилгээний ажилтан Ё.Болормаа 2-р байр, Сайншанд сумын ЗДТГ-ын хууль зүйн мэргэжилтэн Х.Хүрэлмаа 3-р байр тус тус эзэллээ. Шагналыг 4-р сарын 5-ны өдөр Сайншанд хотод зохион байгуулагдсан “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-ний үеэр гардууллаа.

Аймгийн ЗДТГазарын Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах” сургалтын хүрээнд сумдын ЗДТГазарын хууль зүйн мэргэжилтнүүдэд нарт санхүү, төсвийн шинээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийв.

Аймгийн Татварын хэлтсээс 2019.04.14-нд зохион байгуулсан Татварын удирдлагын нэгдсэн системийн тухай сургалтад байгууллагын нягтлан бодогч Д.Отгон хамрагдав.

Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ” зөвлөлдөх уулзалтанд 2019.04.19-ний өдөр албаны дарга, улсын байцаагч, дотоод аудиторуд хамрагдав.

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс “Нэн тэргүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн уриалга” гаргаж, жилийн олон талт арга хэмжээг зохион байгуулж байгаатай холбогдуулан 2019.04.19-ний өдөр архив, бичиг хэргийн ажилтан Т.Анхчимэг хамрагдав.

Аймгийн ЭМГазраас зохион байгуулсан “Ажлын байрны дасгал” сарын аяны хүрээнд Идэвхтэй хөдөлгөөн дасгалд ЭМГазрын чийрэгжүүлэлтийн танхимд дотоод аудитор Д.Отгон, Д.Отгонбаяр, архив бичиг хэргийн эрхлэгч Т.Анхчимэг нар хамрагдав.

Энэ сард 11 албан бичиг хүлээн авч, 5 бичиг төлөвлөж хүргүүлсэн байна.

Энэ оны болон өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлийг шүүхийн байгууллагад шилжүүлэв.

“Ирэх сард зохион байгуулах гол ажлын тухай товч мэдээлэл”

Айраг сумын төсөвт байгууллагууд, сангуудын 2016-2018 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2019.04.29-ний өдрөөс хяналт шалгалтыг гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Байгууллагын дарга, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, дотоод аудитор нар шинээр гарсан хууль, тогтоол, дүрэм, журмын талаар санал солилцох.

Статистикийн хэлтэс

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц: Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд нийт хүн амын 20,0 хувийн мэдээлийг тулган шалгаж хүн ам, өрхийн мэдээллийн санд засвар өөрчлөлт хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллаа. Мөн хүн ам, өрхийн бүртгэлийн шинэчлэгдсэн дэвтрийн загварыг сумдад хүргүүлж, хүн амын мэдээлэл шинэчлэхэд шинэ дэвтрийг хөтлөх, шинээр нэмэгдсэн үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолтын талаар заавар зөвлөмж өгсөн. Нийт өрхийн 20.6 хувь буюу 4390 өрх, хүн амын 22.8 хувь буюу 15884 хүн амын мэдээллийг тулган шалгаж, 1015 өрх, 3121 хүн амын үзүүлэлтийг хүн ам, өрхийн мэдээллийн санд засварласан.

Сар бүрийн хөдөө аж ахуйн мэдээ тайланг 64 багаас, аж үйлдэрийн салбарын мэдээг 60 гаруй аж ахуйн нэгж, иргэдээс, тээврийн салбарын мэдээг 17 аж ахуй нэгжээс цуглуулан авч, нягтлан шалгаж программд шивж дамжууллаа.

2018 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 70 жил хадгалах хадгаламжийн 3 нэгж, байнга хадгалах хадгаламжийн 17 нэгж, түр хадгалах хадгаламжийн 67 нэгж, нийт 87 архивын нэгжийг бүрдүүлэн хугацаанд нь архив бичиг хэрэг хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөв.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээ-2019” төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн сургалтанд хэлтсийн дарга оролцов.

Барилга, аж үйлдвэр, зочид буудал, зоогийн газар, худалдаа, барьцаалан зээлдүүлэх, тээвэр, холбоо, хөдөө аж ахуй, мал эмнэлэг, аялал жуучлал, эрдэм шинжилгээ судалгаа, удирдлагын дэмжлэг үзүүлэх үйлчилгээний салбарын 2018 оны жилийн эцсийн мэдээг сангийн яамны аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлантай тулган шалгасан тодруулгыг хийж Үндэсний статистикийн хороонд дамжуулав.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 3-р сарын танилцуулга болон илтгэлийг бэлтгэж цахимаар хэрэглэгчдэд тархааж, мөн facebook болон цахим хуудсанд байршуулсан.

Хөдөө аж ахуйн салбарын танилцуулгыг 2018 оны мал тооллогын дүнгээр бэлтгэн гаргаж хэрэглэгчдэд тархаав.

2019 оны 1-р улирлын мэдээ буюу барилга, худалдаа, зочид буудал, зоогийн газар, барьцаалан зээлдүүлэх, холбоо, сүм хийд, нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээ, мэргэжлийн түр сургалт, төрийн бус байгууллага, аялал жуулчлал, худалдаа, мал эмнэлгийн салбарын нийт 375 аж ахуй нэгжээс мэдээ, тайланг цуглуулж, алдааг засварлан, программд шивж Үндэсний статистикийн хороонд дамжуулах ажил 100 хувьтай хийгдэж дуусав.

2018 оны жилийн эцсийн Нийгэм, эдийн засгийн танилцуулгыг бэлтгэн 170 гаруй хэрэглэгчдэд тархаав.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого болон Байшин, орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд ХАӨМС-д байгаа хаягийн мэдээллийн хэсгийг гудамж, зам талбайн албан ёсны нэршилд тулгуурлан шинэчилж, хаягийн мэдээллийн санг сум багаас нэгтгэн авч Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.

2019 оны 4-р сард Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм эдийн судалгаанд Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Иххэт, Айраг, Хөвсгөл сумдын нийт 76 өрх хамрагдах юм. Одоогоор Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Иххэт, Айраг, Хөвсгөл сумдын 66 өрхөөс судалгааг авч, Үндэсний Статистикийн хороонд дамжуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Орон нутгийн өмчийн газар:

Орон нутгийн өмчийн хүрээнд: Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний тайланг нэгтгэн гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнаж хүргүүлэн улсын хэмжээнд шилдэг 3 аймгаар шалгарсан.

Чандмань-Илч ОНӨХХК, Эм эргэлтийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг 2019 оны 03 сарын 05-наас 04 сарын 8-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн санал хүлээн авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 04 сарын 08-ны өдрийн хуралд оруулж 84,7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 38,8 сая төгрөгийн балансаас балансад шилжүүлэх, 695,2 сая төгрөгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх 21,8 сая төгрөгийг худалдан борлуулахаар шийдвэрлүүлсэн

Худалдан авах ажиллагааны хүрээнд: 2019 оны аймгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг хялбаршуулсан 14 ажлыг цахим системээр зарласан. Үүнд:

1. 3, 4 –р багийн иргэдийн хөгжлийн төв барих ажлыг Улаанбарах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажлыг 04 дүгээр сарын 08-ны өдөр нээнэ.

2. Замын-Үүдийн 1-р цэцэрлэгийн гадна дулаан шугам сүлжээний ажлыг 04 дүгээр сарын 08-ны өдөр нээнэ.

3. Даланжаргалан суманд багийн төв барих 04 дүгээр сарын 08-ны өдөр нээнэ.

4. Алтанширээ сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж барих ажлыг 04 дүгээр сарын 05-ны өдөр зарласан.

5. Аймгийн төвийн Гэр бүлийн талбайд лед дэлгэц байрлуулах ажлыг 04 дүгээр сарын 04-ны өдөр зарласан.

6. Сайншанд сумын 2-р сургууль, Замын-Үүд сумын 2-р сургуульд турникет систем суурилуулах

7. Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажлыг 04 дүгээр сарын 12-ны өдөр зарласан.

8. Өргөн сумын Спорт заалын барилга барих ажлыг 04 дүгээр сарын 12-ны өдөр зарласан.

9. Сайншанд суманд Кино театрын барилга ажлыг 04 дүгээр сарын 12-ны өдөр зарласан.

10. Сайншанд суманд баригдах Кино театрын барилга барих ажил 04 дүгээр сарын 15-ны өдөр зарласан.

11. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гемодиализын аппарат худалдан авах ажил 04 дүгээр сарын 15-ны өдөр зарласан.

12. Замын-Үүд суманд баригдах 150 ортой цэцэрлэгийн барилга барих ажил 04 дүгээр сарын 16-ны өдөр зарласан.

13. Эрдэнэ сумын спорт талбай барих ажил 04 дүгээр сарын 17-ны өдөр зарласан.

14. Сайншанд сумын 4-р багт иргэдийн хөгжлийн төв барих ажлыг 04-р сарын 08-ны өдөр нээн нарийвчилсан үнэлгээ хийж “Их булаг трейд” ХХК, “Навтгар хайрхан” ХХК-ний материал шаардлага хангаагүй тул хүчингүй болон 04 дүгээр сарын 19-ний өдөр дахин зарласан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийж 30 тендерт нарийвчилсан үнэлгээ хийж байна. Үүнд:

1. Мандах сумын соёлын төвийн их засварын ажлыг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

2. Эрдэнэ суманд 80 ортой дотуур байр барих ажлыг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

3. Айраг сумын эцэрлэгийн барилгын их засварын тендерийг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

4. Улаанбадрах сумын цэцэрлэгийн барилгын их засварын тендерийг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

5. Улаанбарах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажлын тендерийг 04 дүгээр сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

6. Сайншанд сумын 2-р баг шизүокагийн гудамжны 0,5 км автозамыг шинэчлэх ажлын тендерийг 04 дүгээр сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

7. Сайншанд сумын 4-р багийн 12-р цэцэрлэг, 320 хүүхдийн сургууль өрхийн эмнэлэг хүртэл автозам шинээр барих ажлын тендерийг 04 дүгээр сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

8. Мандах сумын соёлын төвийн их засварын ажлыг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

9. Эрдэнэ суманд 80 ортой дотуур байр барих ажлыг 04 –р сарын 01-ний өдөр нээсэн үнэлгээ хийж байна.

10. Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажлын үнэлгээ хийж байна.

11. Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай авто зам, 6.85 км барих ажил

12. Дэлгэрэх, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зураг төсвийн ажил

13. Дэлгэрэх сумын 0,4 квт-ын ЦДАШ-ын өргөтөл хийх ажил
14. Газрын төлөв байдалд чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
15. Залуус хорооллын 1.1 км зам, Сайншанд сумын ЗДТГ-ын авто зогсоол хүртэлх замын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
16. Иххэт сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
17. Сумдад бохир ус шингээх байгууламж шинээр барих зураг төсөв боловсруулах ажил техникийн санал нээсэн.
18. Сайншанд 3 дугаар цэцэрлэгийн барилгын гадна дулаан цэвэр усны шугам, сүлжээ, дээврийн засварын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
19. Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
20. Дэлгэрэх сумын 0.4 квт-ын ЦДАШ-ын өргөтгөлийн ажлын нарийвчилсан үнэлгээ хийж байна.
21. Дэлгэрэ, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын техникийн санал нээсэн
22. Хөвсгөл сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсвийн ажлын техникийн санал нээсэн.
23. Эрдэнэ сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсвийн ажлын техникийн санал нээсэн.
24. Хатанбулаг сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсвийн ажлын техникийн санал нээсэн.
25. Даланжаргалан сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам, сүлжээ, барилга байгууламжийн ажлын нарийвчилсан үнэлгээ хийж байна.
26. Шинэ хөдөө-Дорноговь төслийн ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна
27. Хөвсгөл суманд багш нарын 4 айлын орон сууц барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
28. Дэлгэрэх суманд төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
29. Сайншанд сумын 2-р сургууль, Замын-Үүд сумын 2-р сургуульд турникет систем суурилуулах ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.
30. Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай авто зам /6.85 км/ барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Гэрээ байгуулсан 13 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

1. Улаанбарах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажлын тендерт 04 дүгээр сарын 08-ны өдөр хариу мэдэгдэл хүргүүлсэн.
2. Сайншанд сумын 2-р баг шизүокагийн гудамжны 0,5 км автозамыг шинэчлэх ажлын тендерт 04 дүгээр сарын 08-ны өдөр хариу мэдэгдэл хүргүүлсэн.
3. Сайншанд сумын 4-р багийн 12-р цэцэрлэг, 320 хүүхдийн сургууль өрхийн эмнэлэг хүртэл автозам шинээр барих ажлын тендерт 04 дүгээр сарын 08-ны өдөр хариу мэдэгдэл хүргүүлсэн.
4. Айраг сумын эцэрлэгийн барилгын их засварын ажлын тендерт 04 дүгээр сарын 08-ны өдөр хариу мэдэгдэл хүргүүлсэн.
5. Сайншанд сумын 4-р багийн Иргэдийн хөгжлийн төв барих тендерийг 04 дүгээр сарын 11-ны өдөр хариу мэдэгдэл хүргүүлсэн.
6. Айраг сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын тендерийг 04 дүгээр сарын 01-ний өдөр нээж нарийвчилсан үнэлгээ хийн “Хул шанд” ХХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.
7. Замын-Үүд сумын 2-р цэцэрлэгийн барилгын дотор халаалтын системийг засварлаж, шинэчлэх ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “Миний Сайншанд” ХХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

8. Айраг сумын ариутгах татуургын шугам, насос станцын барилга, тоног төхөөрөмж угсрах ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “Чандмань-Илч” ОНӨХХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

9. Улаанбадрах сумын сургуулийн барилгын их засварын ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “БЭМЭС” ХХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

10. Сайншанд сумын 2 дугаар баг Шизуокагийн гудамжны 0.5 км автозамыг шинэчлэх ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “Дорноговь АЗЗА” ТӨХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

11. Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “Гом-Илч” ХХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

12. Сайншанд сумын 4 дүгээр багийн 12 дугаар цэцэрлэг, 320 хүүхдийн суудалтай сургууль, Өрхийн эмнэлэг хүртэл автозам шинээр барих ажлын нарийвчилсан үнэлгээ хийн “Дорноговь АЗЗА” ТӨХК шалгаран гэрээ байгуулах эрх олгосон.

13. Улаанбадрах суманд инженерийн хийцтэй бэлчээрийн 2 ширхэг гүний худаг гаргах ажлын тендер шалгаруулалт хүчингүй болон “Эхний эхэн” ХХК-тай шууд гэрээ байгуулсан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийх 13 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

1. Хатанбулаг сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж барих ажил 4-р сарын 29-ний өдөр нээлт хийнэ.
2. Сайншанд сумын 4-р багт спортын задгай талбай бүхий “Буянт ухаа” цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил 4-р сарын 29-ний өдөр нээлт хийнэ.
3. Айраг суманд соёл, спортын төвийн барилга барих ажил 4-р сарын 29-ний өдөр нээлт хийнэ.
4. Улаанбадрах суманд соёл, спортын төвийн барилга /200 суудал/ барих ажил 4-р сарын 30-ны өдөр нээлт хийнэ.
5. Хөвсгөл суманд соёл, спортын төвийн барилга /200 суудал/ барих ажил 5-р сарын 01-ний өдөр нээлт хийнэ.
6. Сайншанд суманд баригдах Соёл, спорт цогцолборын барилга /1000 суудал/ барих ажил 5-р сарын 02-ны өдөр нээлт хийнэ.
7. Сайншанд сумын 5-р багт Багийн төв барих ажил 5-р сарын 03-ны өдөр нээлт хийнэ.
8. Газрын төлөв байдалд чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх ажил 04 дүгээр сарын 23-ны өдөр нээнэ.
9. Залуус хорооллын 1.1 км зам, Сайншанд сумын ЗДТГ-ын авто зогсоол хүртэлх замын ажил 04 дүгээр сарын 25-ны өдөр нээнэ.
10. Иххэт сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажил 04 дүгээр сарын 26-ны өдөр нээнэ.
11. Сумдад бохир ус шингээх байгууламж шинээр барих зураг төсөв боловсруулах ажил 04 дүгээр сарын 26-ны өдөр нээнэ.
12. Сайншанд 3 дугаар цэцэрлэгийн барилгын гадна дулаан цэвэр усны шугам, сүлжээ, дээврийн засварын ажил 04 дүгээр сарын 26-ны өдөр нээнэ.
13. Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажил 04 дүгээр сарын 26-ны өдөр нээнэ.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс:

Засгийн газраас ирсэн 5 тогтоол, 3 хуралдааны тэмдэглэл болон аймгийн Иргэдийн Төлөөлөнчдын Хурлын 32 тогтоолыг хяналтанд авч, удирдлагуудад танилцуулан, холбогдох мэргэжилтнүүдэд хувиран хүргүүлжээ.

Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2019 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, аймгийн Засаг даргад танилцуулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны үр дүнгийн гэрээг дүгнэсэн дүнг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажууллаа.

Ухаалаг засаглал төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу <http://dornogovi.unelgee.gov.mn/> цахим хуудсын ашиглалт болон аймгийн цахим хуудасны шинэчлэлийн ажилд хяналт тавин ажилласан.

Байгууллагын дотоод журмын төслийг боловсруулж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтад тусгагдсан 21 бодлогын бичиг баримтыг хавтасжуулж, дотоод хэрэгцээнд бэлтгэсэн.

Хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэв.

Дорноговь аймгийн 2018 оны үйл ажиллагаанаас 2 ажлыг сонгон бусад аймгуудад туршлага болгон танилцуулах ажлын хүрээнд “Маргаашийн нар багшийн гар дээр мандана”, “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн танилцуулга бэлтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон аймгийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1 дүгээр улирлын тайланг цахимаар хяналтад авсан. Хэлтсүүдээс Хууль, эрх зүйн хэлтэс, сумдаас Замын Үүд сум, агентлагуудаас Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар тайлангаа цахимд илгээгээгүй байна.

ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Харилцан суралцах арга зүй” сэдэвт сургалтанд 2, Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг” зөвлөлдөх уулзалтад 1, Сангийн яамнаас зохион байгуулсан “Тогтвортой амьжиргаа-3” төслийн ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх талаарх сургалтанд 1 мэргэжилтэн тус тус хамрагдан, мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг /БТСГ, ХХААГ, ШШГГ/-ийн үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Даланжаргалан, Хөвсгөл, Хатанбулаг сумдын ЗДТГ-ын бодлогын мэргэжилтнүүд болон төсөвт байгууллагын 84 албан хаагчдыг хамруулан, “Бодлого төлөвлөлт, хяналт-

шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтыг хийж, ажлын байран дээр чадавхижуулах болон мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан.

Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан сумдын Хуульзүйн мэргэжилтнүүдийн сургалтанд “Тайлан мэдээнд гарч буй алдаа, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт хийж, мэргэжил арга зүйгээр хангав.

Аймгийн ИТХ-аар батлагдан хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн 2019 оны төлөвлөгөөг холбогдох мэргэжилтнүүдээс авч, хяналт шинжилгээ үнэлгээний цахим хуудсанд оруулах ажил хийгдэж байна. Хууль эрх зүйн хэлтэс-3, Нийгмийн бодлогын хэлтэс-9, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөтийн хэлтэс-3 дэд хөтөлбөрийн төлөвлөгөө ирүүлээгүй байна.

Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний бэлтгэл ажилд хэлтсийн мэргэжилтнүүд өгөгдсөн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, зөвлөгөөнд бүгд хамрагдсан.

Удирдах ажилтан ба спортын арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулсан.

---000---